



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.2-т заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг нь бохир усны төвийн шугамд холбогдож цаашид бохир усны шахуургын барилга байгууламжийг ашиглахгүй болсонтой холбогдуулан тус газрын эзэмшил бүхий газарт байрлалтай “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын баланст бүртгэлтэй 1,534,413.00 (нэг сая таван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун арван гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй хавсралтад дурдсан бохирын станцын барилга, цахилгааны тоног төхөөрөмжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН

1119101050

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
БАРИЛГА, ЦАХИЛГААНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Тод хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт	Эзэмшигч байгууллага
1	Барилга КНС /бохирын станцын барилга/	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	472,500.00	472,500.00	-	ОСНААУГ-ын техникийн комиссын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн акт	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
2	ННС хүчний самбар ЕСО	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	717,477.00	717,477.00	-		
3	ННС хүчний самбар 400А	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	344,436.00	344,436.00	-		
ДҮН				1,534,413.00	1,534,413.00	-		